



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Могод сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2025/122/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2025 он	Дарга, тэргүүлэх аудиторовын албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn Аудитор: А.Сувдаа Утас: 70342495 Цахим хаяг: suvdaaa@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.02.24, № 201
танай _____ ны № _____ т

МОГОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Х.МӨНХ-АЛТАЙ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Могод сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв тогтоолсон байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

"Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолын дагуу тус байгууллагын албан хаагчдын үндсэн цалинг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс шинэчлэн баталсан мөн Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолын дагуу "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, аймгийн ИТХ-ын 2023 оны XIX/08 дугаар тогтоолоор орон нутгийн нэмэгдлийг олгосон байна. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 69.3 хувиар өссөн байна.

Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол

632502324

асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Могод сумын Засаг даргын тамгын газар нь 1 хөтөлбөр 8 зориулалт арга хэмжээний хүрээнд 1,015.1 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж 933.9 сая төгрөгийг зарцуулж 81.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛЫН
АЛБАН ҮҮРГТИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ЭНХЦООДОЛ

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/мянган төгрөг/

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31.
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	68,206.8	82,066.1
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,123,604.4	2,544,808.8
Нийт хөрөнгийн дүн	2,191,811.2	2,626,874.9
Нийт өр төлбөрийн дүн	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,191,811.2	2,626,874.9
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,191,811.2	2,626,874.9
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	933,205.7	1,588,445.9
Үйл ажиллагааны зардлын дүн	806,436.8	1,137,381.8
Үйл ажиллагааны үр дүн	126,769.0	451,064.1
Үйл ажиллагааны бус үр дүн	(1,325.2)	(16,000.3)
Үйл ажиллагааны нийт үр дүн	125,443.8	435,063.8
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,066,367.4	2,191,811.2
Тайлант оны үр дүн	125,443.8	435,063.8
Эцсийн үлдэгдэл	2,191,811.2	2,626,874.9
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	683,321.2	1,044,197.4
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	683,321.2	1,019,639.6
Үйл ажиллагааны ЦМГ	(0.0)	24,557.8
Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	(24,557.8)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(0.0)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	933,931.0
Урсгал зардал	-	909,373.2
Хөрөнгийн зардал	-	24,557.8
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	933,931.0
Улсын төсвөөс санхүүжих	-	-
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тайлант онд тус байгууллага “Тамгын газрын эрхэм зорилго нь Засаг даргын бүрэн эрхээ тасралтгүй, хэвийн, үр нөлөөтэй хэрэгжүүлэх нөхцөлийг хангаж, иргэдэд түргэн шуурхай, ил тод нээлттэйгээр төрийн үйлчилгээг хүргэхэд оршино” зорилгын хүрээнд ажилласан байна.

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 586,606.6 мянган төгрөгийн орлогын 25 удаагийн гүйлгээ, 67,114.5 мянган төгрөгийн зарлагын 5 гүйлгээг бүрэн мэдээлээгүй нь Шилэн дансны тухай

хуулийн 6.4.5, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтын 3.2.10-д заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Тав. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хүний нөөцийн программд албан хаагчдын мэдээллийг үнэн зөв тусгасан эсэх, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулах газрын 2019 оны 271 дүгээр тогтоол "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журам, аймгийн ИТХ-ын 2024 оны 25/08 дугаар тогтоолыг хэрэгжилтийг хянах үзэх.

Зургаа. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 9,152.2 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа:

- Цалин тооцож олгохдоо илүү олгосныг суутгаж аваагүй, авлагаар тусгаагүй нь УСНББОУС-1,2 тасалбар болголт, эрх ба үүрэг батламж мэдэгдэл,
- Нэмэлт санхүүжилтийн данснаас сэг зэм устгахтай холбоотойгоор урьдчилгааг олгохдоо авлагын дансаар дамжуулаагүй нь УСНББОУС-1,2 тасалбар болголт, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Аудитаар нийт 5,752.4 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 1,500.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 4,060.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 192.4 мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 5,752.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 6,344.2 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

6.1 Төлбөрийн акт

1. Төсвөөс Дашинчилэн, Бугат, Хангал сумын ойн арга хэмжээнд зориулж нийт 1,500.0 мянган төгрөгийг хандивласан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах,"* 25 дугаар зүйлийн 25.10-т "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хандивласан төсвийн хөрөнгийг улсын орлого болгох.

6.2 Албан шаардлага

1. Баяр наадмын зардалд 4,060.0 мянган төгрөгийг нярвын дансаар дамжуулж бай шагналд зарцуулсан анхан шатны баримтын бүрдэл дутуу нь Нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх"-ыг зөрчсөн, тохиолдсон байх, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож холбогдох хууль, журмын заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах

6.3 Зөвлөмж

1. Цалинтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хүний нөөцийн программд албан хаагчийн мэдээллийг алдаатай оруулснаас алба хаасан хугацааны нэмэгдлийг зөрүүтэй тооцож олгосон байна.

Өгсөн зөвлөмж: Хүний нөөцийн программд албан хаагчийн мэдээллийг үнэн зөв оруулах, дотоод хяналтыг сайжруулах.

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 111 нэр төрлийн 151 тооны хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн өмчийн бодлого зохицуулах газрын 2019 оны 271 дүгээр тогтоол "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журам, аймгийн ИТХ-ын 2024 оны 25/08 дугаар тогтоолын дагуу элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах.

Долоо. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган.төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Могод сумын ЗДТГ	2	9,152.2	1	1,152.2	1	8,000.0	2	9,152.2	0	0	0	0
Дүн	2	9,152.2	1	1,152.2	1	8,000.0	2	9,152.2	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган.төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Могод сумын ЗДТГ	4	5,752.4	1	1,500.0	1	4,060.0	2	192.4	0	0	0	0
Дүн	4	5,752.4	1	1,500.0	1	4,060.0	2	192.4	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган.төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Могод сумын ЗДТГ	1	653,721.0	0	-	1	653,721.0	0	-
Дүн	1	653,721.0	0	-	1	653,721.0	0	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн	0	-	0	-	0	-	0	-
Нийт дүн	1	653,721.0	0	-	1	653,721.0	0	-

Найм. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Байгууллага, нэгжийн тоо	Санал дүгнэлтийн хэлбэр
---	--------------------------	-------------------------

	Төсвийн захирагчийн ангилал	Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр						
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

-oOo-